

ГАЗАР ТАРИАЛАН

Танилцуулага

2015

Монгол улсын Засгийн газраас эх орныхоо хэрэгцээт буудай, төмс, хүнсний ногоог дотооддоо үйлдвэрлэх, хангамжийг хэмэгдүүлэх зорилгоор 1959 онд Атар газрыг эзэмших аяныг хэрэгжүүлснээр газар тариалангийн салбарыг эдийн засгийн бие даасан салбар болгон хөгжүүлсэн юм.

Өнөөдөр тариалангийн салбарт 1190 аж ахуйн нэгж, 34.5 мянган өрхийн тариалан эрхлэгч, нийтдээ 65.0 мянга гаруй тариаланч, механикжуулагч, жимсчид 706.0



мян.га эргэлтийн талбайд үйл ажиллагаа явуулж байна. Одоогоор газар тариалангийн салбарт улаанбуудай, арвай овъёос, хөх тариа, гурвалжин будаа, шар буурцаг, эрдэнэшиш, рапс, төмс, 30 орчим төрлийн хүнсний ногоо тариалж байна.

Газар тариаланд оруулсан хөрөнгө оруулалтын 60-аас илүү хувийг хувийн хэвшил эзэлж байна. Газар тариалангийн салбарын техник технологи үр тарианы үйлдвэрлэлд 50 гаруй хувь төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлд 30 гаруй хувь шинэчлэгдээд байна. Сүүлийн 6 жил дараалан нэгж талбайгаас 13.2-16.0 цн үр тариа, 122.5-149.9 цн төмс, 125.7-138.6 цн хүнсний ногоо тус тус хураан авсан байна.

Газар тариалангийн эдэлбэр газрын ашиглалт



д/д	Бүсийн нэр	Тариалангийн нийт талбай, га	Ашиглагдаж буй талбай, га	Атаршсан талбай, га	Ашиглалтгүй талбайн эзлэх хувь
1	Төв	821 208	569 145	252 063	30.7
2	Хангай	139 768	440 98	95 670	68.4
3	Баруун	126 393	22 302	104 091	82.4
4	Зүүн	181 753	104 811	76 942	23.6
5	Говь	376	376	0	0.0
Улсын дүн		1 269 498	740 732	548 766	51.9

Газар тариалангийн салбарыг уур амьсгал, хөрсний бүтэц шинж чанараас хамаарч төвийн, зүүн, баруун, хангайн, говийн бүсэд хуваадаг.

ЗҮҮНБҮС

Хэрэгжүүлэх ажлууд

- Техник, технологийн шинэчлэлийг эрчимжүүлэх, нэвтрүүлэх,
- Хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх,
- Талбайг малаас хамгаалах, хашаажуулах,
- Хөрсний үржил шимийг сайжруулах бордоо, ургамал хамгааллын бодисийн зохистой хэрэглээг нэмэгдүүлэх,
- Усалгаатай тариаланг нэмэгдүүлэх,
- Атаршсан талбайг эргэлтэд оруулах,



д/д	Аймагын нэр	Тариалангийн нийт талбай, га	Ашиглагдаж буй талбай, га	Атаршсан талбай, га	Ашиглалтгүй талбайн эзлэх хувь
1	Дорнод	89844	53650	36194	23.2
2	Хэнтий	83292	30730	52562	63.1
3	Сүхбаатар	28617	431	28186	98.5
	Дүн	181753	104811	76942	53.3

БАРУУНБҮС

Хэрэгжүүлэх ажлууд

- Техник, технологийн шинэчлэлийг эрчимжүүлэх, нэвтрүүлэх,
- Хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх,
- Талбайг малаас хамгаалах, хашаажуулах,
- Хөрсний үржил шимийг сайжруулах бордоо, ургамал хамгааллын бодисийн зохистой хэрэглээг нэмэгдүүлэх,
- Усалгаатай тариаланг нэмэгдүүлэх,
- Атаршсан талбайг эргэлтэд оруулах,



д/д	Аймагын нэр	Тариалангийн нийт талбай, га	Ашиглагдаж буй талбай, га	Атаршсан талбай, га	Ашиглалтгүй талбайн эзлэх хувь
1	Увс	50509	12713	37796	74.8
2	Баян-Өлгий	1892	1289	603	31.9
3	Ховд	8293	2836	5457	65.6
4	Завхан	60580	4790	55790	92.1
5	Говь-Алтай	5119	654	4465	87.2
	Дүн	126393	22302	104091	82.4

ГОВИЙН БҮС

Хэрэгжүүлэх ажлууд

- Техник, технологийн шинэчлэлийг эрчимжүүлэх, нэвтрүүлэх,
- Хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх,
- Хөрсний үржил шимийг сайжруулах бордоо, ургамал хамгааллын бодисийн зохистой хэрэглээг нэмэгдүүлэх,
- Усалгаатай тариаланг нэмэгдүүлэх,
- Хамгаалагдсан хөрсний тариаланг, жимс, жимсгэний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх



д/д	Аймагын нэр	Тариалангийн нийт талбай, га	Ашиглагдаж буй талбай, га	Атаршсан талбай, га	Ашиглалтгүй талбайн эзлэх хувь
1	Дорноговь	60	60	0	0.0
2	Дундговь	101	101	0	0.0
3	Өмнөговь	164	164	0	0.0
4	Говьсүмбэр	51	51	0	0.0
	Дүн	376	376	0	0.0

ХАНГАЙН БҮС

Хэрэгжүүлэх ажлууд

- Техник, технологийн шинэчлэлийг эрчимжүүлэх, нэвтрүүлэх,
- Хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх,
- Талбайг малаас хамгаалах, хашаажуулах,
- Хөрсний үржил шимийг сайжруулах бордоо, ургамал хамгааллын бодисийн зохистой хэрэглээг нэмэгдүүлэх,
- Атаршсан талбайг эргэлтэд оруулах



д/д	Аймагын нэр	Тариалангийн нийт талбай, га	Ашиглагдаж буй талбай, га	Атаршсан талбай, га	Ашиглалтгүй талбайн эзлэх хувь
1	Архангай	47463	7347	40116	84.5
2	Өвөрхангай	38676	6204	32472	84.0
3	Хөвсгөл	42180	29818	12362	29.3
4	Баянхонгор	11449	729	10720	93.6
5	Дүн	139768	44098	95670	68.4

ТӨВИЙН БҮС

Хэрэгжүүлэх ажлууд

- Техник, технологийн шинэчлэлийг эрчимжүүлэх,
- Хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх,
- Газрын эзэмшилт, ашиглалтыг сайжруулах
- Эрчимжсэн МАА-н бүсийг тогтоох, талбайг бэлчээрийн малаас хамгаалах, хашаажуулах,
- Хөрсний үржил шимийг сайжруулах бордооны зохистой хэрэглээ, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх,
- Талбайг геометрийн зөв хэлбэрт оруулж өргөжүүлэх, чулуугүйжүүлэх,



д/д	Аймагын нэр	Тариалангийн нийт талбай, га	Ашиглагдаж буй талбай, га	Атаршсан талбай, га	Ашиглалтгүй талбайн эзлэх хувь
1	Сэлэнгэ	329708	309244	20444	6.2
2	Төв	327193	155586	171607	52.4
3	Дархан-Уул	41619	31922	9697	23.3
4	Булган	113697	63805	49892	43.9
5	Орхон	9011	8588	423	4.7
	Дүн	821208	569145	252063	30.7

Ягаад Монгол, Давуу тал

- ◆ Ази тивийн цээжинд орших байршил.
- ◆ Байгаль-цаг уурын хатуу ширүүн нөхцөлд дасан зохицож, биологийн онцгой шинжийг хадгалсан бүтээгдэхүүн.
- ◆ Монгол улсын нийт ажиллагсдын 35 орчим хувь тухайн салбарт ажиллаж хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын орлогоор амьжиргааныхаа үндсэн эх булгийг бүрдүүлж байдаг.

Боломжууд

Ажиллах хүчний мэргэжил, чадварыг дээшлүүлэх шаардлага
Энгийн болон инженерийн хийцтэй услалтын системийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах, усалгааны бусад дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх замаар усалгаатай тариаланг хөгжүүлэх
Шинээр томоохон хэмжээний усалгаатай тариалан, хадлан бэлчээр бий болгох боломжтой газар нутгийн хайгуул, судалгаа, зураг төсөл боловсруулах, систем байгуулах ажлыг хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлэх.

Төрөөс газар тариалангийн талаар баримтлах бодлого

Хөрс, уур амьсгал, эдийн засгийн нөөцөө зохистой ашиглаж, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд газар тариалангийн бодлого чиглэгдэнэ.

Тариалангийн газрыг өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах замаар газрыг зах зээлийн эргэлтэнд оруулж, ашиглалтыг сайжруулах:

- * Тариалангийн газрын зориулалтыг өөрчлөх, хөрсний чанар байдалд хяналт тавих, усалгаатай тариалангийн зориулалтаар атар газар эзэмших, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд тариалангийн газрыг ашиглуулах, газар тариаланд үзүүлэх төрийн дэмжлэг, хөрөнгийн эх үүсвэрийн талаархи эрх зүйн орчныг бий болгох.
- * Сэргээн засварлах услалтын системийн зураг, төслийг өмчлөгч, эзэмшигчийнх нь захиалгаар хийлгүүлж, түүнийг хэрэгжүүлэхэд төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх, шинээр усалгаатай тариалан эрхэлж буй иргэн, хуулийн этгээдийг эхний 3 жилд орлогын татвараас, импортоор авч байгаа усалгааны тоног төхөөрөмжийг нэмэгдсэн өртгийн албан татвараас хөнгөлөх эрх зүйн үндсийг бүрдүүлэх

Тариалангийн газрыг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид ашиглуулах

- * Тариалангийн зориулалтаар гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид ашиглуулах газрын хэмжээг тарих ургамлын төрөл, газар зүйн байршлыг харгалзан Засгийн газар тогтооно.
- * Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тариалангийн зориулалтаар газар ашиглах тухай хүсэлтийг хянаж шийдвэрлэх, түүнтэй газар ашиглах гэрээ байгуулахад Газрын тухай хуулийг дагаж мөрдөнө.
- * Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжтэй байгуулах газар ашиглах гэрээнд тариалангийн газрыг ашиглах төсөл, хөтөлбөр, тариалангийн үйлдвэрлэлд нэвтрүүлэх шинэ техник, технологи, тариалангийн үйлдвэрлэлд оруулах хөрөнгө оруулалтын доод хэмжээ, хууль тогтоомжид нийцсэн бусад нөхцөл, болзол зэрэг тусгагдана.

Холбоо барих

Баттөгс Анужин
Сурталчилгаа, зөвлөх үйлчилгээний
мэргэжилтэн
Хөрөнгө Оруулалтын Газар
15141 ЗГ-ын XI байр, Самбуугийн гудамж-11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар, Монгол Улс
Утас: 976-11320706
Факс: 976-324076
Цахим хаяг: anujin@investmongolia.com

Ашигтай холбоосууд

Хүнс, Хөдөө Аж Ахуйн яам
<http://www.mofa.gov.mn/new/>
Нийслэлийн Хөдөө Аж Ахуйн Ассоциаци
Мал, Тариалангийн Эрсдэл Судлах Төв ТББ